



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар

A/617

Ховд

Хөрөнгө гаргах зөвшөөрөл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.5, 41.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх зардалд 8 450 000 төгрөгийг орон нутагт хийгдэж буй барилга угсралт, их засварын ажлын техник хяналтын зардлаас хавсралтад заасны дагуу зарцуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/-д зөвшөөрсүгэй.

2. Дээрх зардлын 8 450 000 төгрөг /Найман сая дөрвөн зуун тавин мянган/-ийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн сангийн нэмэлт дансанд шилжүүлж, гүйлгээ хийхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

3. Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хөрөнгийг нягтлан бодох хуулийн дагуу данс бүртгэлд тусгаж, тайлагнахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/617 Ch
02 2794

Аймгийн засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 20-ны өдрийн
А/ 617 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Бараа, үнэ бүхий зүйлийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ	Дүн
1	ISO 9001:2015 ЧМСтандарт	багц	1	8000000	8000000
2	ISO самбар	ш	1	450000	450000
Дүн					8450000

-oOo-